



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 0149

Улаанбаатар хот

Ч.Мөнхзаяад сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.13, 37.1.16, 48 дугаар зүйлийн 48.1.2, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, 1.3.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Чулуунбатын Мөнхзаяа нь холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зөрчиж ажил тасалсан нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дотоод хяналт шалгалтаар тогтоогдсон тул түүнд 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс “Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ч.Мөнхзаяад үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхтамир)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

112402198

ТУШААЛ ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ


2024.09.06

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Ч.Мөнхзаяад сахилгын шийтгэл ногдуулах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/479 дүгээр тушаалыг Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Чулуунбатын Мөнхзаяад албан бичгээр танилцуулсан болно.

№	Албан хаагчийн		Тушаалын дугаар	Гарын үсэг
	Албан тушаал	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр		
1	Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч	Чулуунбатын Мөнхзаяа	Б/479	

ТУШААЛ ТАНИЛЦУУЛСАН



Ж.ПҮРЭВНЯМ

/Улсын бүртгэлийн ерөнхий газрын
Тамгын газрын мэргэжилтэн/